

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА

Зам, тээврийн хөгжлийн яамны 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 38-07-076/10 удирдамжийн дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэст төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. **Улсын дугаарын давхардал, дугаарын стандартын зөрчилд** авч байгаа арга хэмжээ, улсын дугаар хадгалах, сольж байгаа байдалд хяналт шалгалт хийв. Улсын дугаар хадгалж байгаатай холбоотой 45 зөрчил, улсын дугаар хууль буцаар олгосон 5 зөрчил, улсын дугаарын давхардалтай холбоотой 11 зөрчил стандартын бус дугаартай холбоотой 8 зөрчил дутагдал гарсан болно. Эдгээрээс газар дээр нь шийдвэрлэх боломжтой 18 зөрчлийг газар дээр нь шийдвэрлэсэн.